



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2024 оны 05 сарын 17 өдөр

Дугаар А/10

Бат-Өлзий сум

Тендерийн гүйцэтгэгчийг сонгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.1, 30 дугаар зүйлийн 30.1 дэх хэсэг, “2024 оны төсөв батлах тухай” сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 18/03 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Үнэлгээний хорооны 2024 оны 05 дугаар сарын 17-ны өдрийн 02 дугаар дүгнэлт, зөвлөмжийг үндэслэн Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрны хатуу эдлэл худалдан авах ажлыг “Их жээт” хязгаарлагдмал хариуцлагатай компаниар гүйцэтгүүлсүгэй.

2. Тендерт шалгарсан аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулж, ажлын явцад хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Н.Бат-Эрдэнэ)-д үүрэг болгосугай

3. Зардалд шаардагдах 40,600,000 (дөчин сая зургаан зуун мянга) төгрөгийг гэрээний дагуу Орон нутгийн хөгжлийн сангийн бусад хөрөнгө данснаас зарцуулахыг Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч (Б.Пүрэвсүрэн)-д зөвшөөрсүгэй.

4. Шалгарсан аж ахуйн нэгж санхүүжилтээ авахад шаардагдах материалыг бүрдүүлэн авч баримтжуулахыг Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч (Б.Пүрэвсүрэн)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



С.АМГАЛАН